

## ХРИСТИЙН ШАШНЫ НЭСТОРЫН УРСГАЛД ХОЛБОГДУУЛЖ БОЛОХ ГУРВАН ДУРСГАЛ

**Алдар Ю. Болдбаатар**

ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургууль, докторант. [Bold@mtu.edu.mn](mailto:Bold@mtu.edu.mn)

**Түлхүүр үг** : *Нэстор-Христийн шашны нэгэн дорно дахинд дэлгэрсэн  
нэгэн урсгал*

*Сири бичэс-Арамей бичгээс салбарласан эртний бичиг. Зарим  
тохиолдолд Нейсториа гэх нь ч буй*

V зууны үед Сири дэх загалмайн шашны сүм хийдийн дотор (Есүс бурхан байсан уу, бурхан-хүн байсан уу гэсэн онолын маргааны улмаас) хагарал гарч улмаар Византийн сүм хийдүүд тэдгээрийн эрхшээлээс ангижрах эрмэлзлэл бүхий шинэ урсгалууд буй болсны нэг нь нэсторын урсгал юм. Уг урсгалыг Константинополийн хамба Нестер үндэслэсний учир тийнхүү нэрлэгдэх болжээ. Хэдийгээр христосын уламжлалт ертөнцөд энэ урсгал дэмжлэг хүлээгээгүй ч Сири, Иран хийгээд дорно зүгийн орнуудад амжилт олж, олон зуун жилээр түгэн дэлгэрсэн ажгуу. Нэсторын загалмайн шашны номлогчид дорнын орнууд түүний дотор Төв Азид багагүй амжилт олж, сургаал номлолоо түгээн, хэдэн зуун жил нөлөөтэй байж чадсаныг алив шашинд эвлэрэнгүй ханддаг нүүдэлчдийн онцлогтой холбон тайлбарлаж болох юм. Загалмайн шашны Нэсторын урсгал Хятад, Төвд, Түрэг (26;75-86), Уйгур (4;3-9), Хар хятан, Зүрчид, Монголчуудын дотор их бага хэмжээгээр дэлгэрч байсан нь түүхийн сурвалж хийгээд археологийн олдворуудаар нотлогддог болно.

Рашид-ад-дины "Судрын чуулган"-д

*"...Хэрэйд аймаг нь тэр үед бусад аймгаас илүү хүчирхэг байв. Есүсийн уриа тэдэнд хүрч, тэд түүнийг шүтжээ. Тэд өөрсдөө монголчуудын төрөл (овог) юм. Нутаг нь монголчуудын нутаг Онон, Хэрлэн..." (16;78) хэмээсэн нь буй.*

Түүнчлэн тэр цагийн Араб дахинаа алдар нэр нь дуурссан эмч, их эрдэмтэн Бар Хэврэүсийн зохиосон он дарааллын бичээс дэх

*"Хэрэйдийн Ван хааны өвөг Буйрук хаан 1009 /бас 1011 он гэх/ онд хоёр зуун мянган турк хэрэйдүүдээ дагуулан христосын шашинд орсон хийгээд түүнд Самаркандын Патриарх Маркус цол хайрласан тухай"*

баттай мэдээг гадаадын олон эрдэмтэд түүний дотор Английн эрдэмтэн А. Саундерс (18;44-45), Францын Рене Груссет (32;244-245), Оросын Л. Гумилев (23;92-93;124-125) нар үндэс болгон 13-р зууны монголын хүчирхэг ханлиг аймаг Хэрэйдүүдийг христийн шашинтан хэмээн үздэг байна. Тэгээд ч Хэрэйд гэдэг үг нь Хэрээс гэдэгтэй холбоотой мэт. Энэ тухай өгүүллийнхээ эцэст товч өгүүлэх болно.

Гильом де Рубрук монгол нутгийн хүйс Хархорин хот хүртэл аялахдаа нэстор шашны элч нар хийгээд нэстор шүтлэгтнүүдтэй уулзаж, учирч явснаа тэмдэглэн бичсэн байдаг. Тэрвээр Батхааны хүү Сартахын тухай

*"...Тэр христос шашныг шүтдэг байж болох боловч христос шашинтан гэж дуудуулах дургүй, харин ...өөрийн нэрийг монгол гэж дуудуулах дуртай" хэмээн бичсэн нь буй.*

Түүнчлэн Найман аймаг эхэн үедээ христосын шашинтай байсан тухай Жувейн "Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх" бүтээлдээ өгүүлсэн бол Дунд Азийн түүхч Шефер ад-дин "Мукаддам" хэмээх зохиолдоо Өлзийттемөр хааны ач Кашлы, Берлас хоёр христосыг шүтдэг байсан тухай мэдээлжээ. Дорно дахиныг судлагч эрдэмтэн В.Бартольд Дундат Азийн түрэг угсаатан ард түмнүүд X зууны үед будда, нэстор шашинг хэрэглэж байсан төдийгүй тэдний дунд лалын шашин дэлгэрэхийн эсрэг хаалт халхавч болгон ашиглаж байсан тухай дурдсан байдаг билээ. (20;1-32) Монголчуудын түүхэн дэх христос шашинтай холбоотой мэдээ

баримт, түүхэн үйл явлуудаас цухас дурдахад: Хар хятаны Гүр хаан Елюй Даши нэстор шүтлэгтнүүдийг ивээн тэтгэж байсан, Европын орнуудад дорно зүгээс христийн шашныг аврахаар хүчирхэг Иоан /Жон/ хаан ирж явна, хожим нь Давид хаан ирж буй гэсэн цуу (13;8)(15;44), Чингис, Өгөөдэй тэргүүдтэй их хаад христосын шашинтнуудад хүндэтгэлтэй ханддаг байсан, Шэнь-сигээс олдсон хятад болон дөрвөлжин үсгээр бичсэн бичээсэнд Хувилай хаан тэднийг аливаа албан татвараас чөлөөлсөн хийгээд Ромын Папаас ном эрдэмд ихэд гэгээрсэн 100 эрдэмтнийг ирүүлэхийг хүссэн, Хүлэг хаан Иль хаадын улсаа байгуулахдаа тэдгээрийг өмгөөлөн лалын шашинтныг ихэд дарсан, Чингисийн хоёрдугаар хүү Цагаадайн оршуулганы бичээс (31;428), Монголын их эзэнт улсын нийслэл Хар хорумд Христос шашны сүм байсан, Хувилайн эсрэг бослого гарган тэмцэхдээ Наян жанжины цэргүүд Христийн загалмайг малгай болон тугандаа сүлд болгосон (31;442), Японд очсон анхны христийн шашинтан Хувилай хааны элч байсан (31;446), монголчууд энэ шашинтныг эрхүүд хэмээдэг асан, монгол хятад хэлээр дөрвөлжин болон ханз үсгээрх "Мөнх тэнгэрийн хүчин дор ... Чингис, Өгөөдэй, Сэцэн, Өлзийт, Хүлэг хаад ..." хэмээн эхэлдэг Шэнь-сигийн хөшөөний бичээс гээд, эдгээрийг цааш дэлгэрүүлэн өгүүлэх аваас их зүйл хүүрнэх хэрэгтэй болно.


Нэстор шашинтны үлдээсэн археологийн энэ мэт олон арван дурсгал Дунд Ази түүний дотор Долоон гол (31;410-415), Хятадын Шинжаан Уйгар, Өвөр Монголын нутгаас олон арваараа олдож энэ чиглэлийн судалгаанд үнэтэй чухал хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ. Миний бие сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр судлагаа хийхийн зорин багагүй материал цуглуулж буй хийгээд 2000-2001 онд Нүүдлийн соёл иргэншлийн өөрчлөлтийг судлах Монгол, Орос, Хятад гурван улсын эрдэмтдийн хамтарсан судалгааны ангид орж ажиллах үед Өвөр монголын Улаанцав аймгийн Дархан Муумянган хошууны төв Батхаалгад нэстор шашинтны бүтээсэн сонирхолтой хэдэн олдворыг үзэж, тэдгээр дурсгалтай нарийвчлан танилцах завшаан олдсон билээ. Эдгээрийн зарим нь 1930-аад оны Манж Го улсын үед Эгами зэрэг Японы эрдэмтэдийн үзэж судалж асан дурсгалууд байв.

Гэвч энэ удаа бид Азийн бусад орны нутаг дэвсгэрт буй нэстор шашны дээрх дурсгалуудын тухай бус харин манай орны нутгаас олдсон археологийн гурван дурсгалыг эрт цагийн христос шашинтай холбон үзэж буйгаа та бүхэнд толилуулья.

### **1. Улаан толгойн сири бичээс**

Энэ бичээсийг 1988 онд Ховд аймгийн Мөнххайрхан сумын Долоон нуурын Улаан толгой гэдэг газраас түүхийн ухааны доктор Д. Баяр, ЭШ-ний ажилтан В. Е. Войтов нар Ховд аймгийн нэгдсэн эмнэлгийн их эмч Батсуурийн туслалцаатайгаар анх олж илрүүлжээ. Бичээсний талаар Д. Баяр "Баруун монголд шинээр илэрсэн эртний бичгийн дурсгалууд" нэртэй өгүүллийг бичиж Шинжлэх ухаан амьдралд сэтгүүлд хэвлүүлэн, анх судлаачдад хүртээл болгосон юм.(2;37;40) Доктор Д. Баяр энэ өгүүлэлдээ "Уг бичээс нь газар нутгийн хувьд Найман улсын нутгийн хил хязгаарт багтаж байгаа болоод бичээсний дээд хэсэгт загалмай байгаа зэргийг үндэслэн нэстор шүтлэгтний үлдээсэн дурсгал болов уу" гэсэн таамаглалыг дэвшүүлжээ. Түүнчлэн Уйгаржин монгол бичгийн анхны хэлбэр байж болох тухай таамаглал дэвшүүлсэн ажээ. Тэр цагаас хойш энэ бичээсний талаар өөр бусад судалгаа шинжилгээний бүтээл гараагүй байна. Энэ бичээсний үсгийн хэлбэр бичигдсэн байдал зэргийг бусад газраас олдсон олон янзийн бичгийн дурсгалуудтай харьцуулан үзвэл эрт цагт /VI-XV зуун/ Төв болон Дунд Азиар дэлгэрч байсан Христосын шашны Нэсторуудын хэрэглэж байсан эртний сири бичиг болох нь харагдаж байна. (Зураг 1)

Евэнгэлийн судрыг сири хэлээр орчуулан бичиглэх, түгээж номлох үйлд хэрэглэж байсан сири буюу нэстор бичиг (арамей бичгийн холын салаа) Согд, Уйгар болон Төв, Дорнод Азийн бичиг үсгийн бусад системд дам нөлөө үзүүлснийг энэ дашрамд тэмдэглэе. (25; 317-319)



Зураг 2. Даян баатарын хүн чулуу



Зураг 1. Улаан толгойн Сири бичээс

Улаан толгойн сири бичээсийг цаашид судлаачдын хүртээл болгох үүднээс мэдэгдэж буй нилээд хэсгийг доор галиглав.

Үүнд:

Бичээсний А хэсэг

1-р мөр: alba mimb h

2. q(\*) sah h ua

Бичээсний Б хэсэг

1-р мөр: u a s l m t

2-р мөр: (\*) l m l s

3-р мөр: \* \* \* \* \*

4-р мөр: \* \* \* \* \*

Улаан толгойн энэхүү бичээс нь монгол орноос олдож байгаа анхны сири бичгийн дурсгал төдийгүй хүн төрлөхтний соёл иргэншлийн нэгэн голомт нутагт үүсэж буй болсон үсгээр эртний сири хэлээр бичигдсэн дурсгал болохын хувьд нүүдэлчдийн соёлын харилцаа, соёл иргэншлийн төдийгүй газар нутгийн хувьд хир өргөн хүрээтэй байсныг илтгэж байна.

## **2. Даян баатарын хөшөө**

Даян баатрын хөшөө хэмээн алдаршсан энэ хүн чулуу Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Даян нуурын дэргэд, хилийн цэргийн заставын өмнө этгээдэд оршино. (зураг2) Цайвар боржин чулуугаар өвөрмөц ур хийцтэй бүтээгдсэн уг хөшөө 160 см өндөр, 38 см өргөн, 20 см зузаан, үүнээс толгойн өндөр 50 см, өргөн нь 38 см-ийн хэмжээтэй байна. Хөшөөнд тухайн хүний онцлог дүр төрх, нүд, хөмсөг, ам, хамар, чих, зүүсэн ээмэг хийгээд живэр сахал, толгойн үс, хацрын төвгөрийг хүртэл уран тод дүрслэн гаргажээ. Түүнчлэн их биенд мөрөвч, бүс, зүүлт чимэглэлийг 2 см өргөн тод шугамаар товойлгон дүрсэлсэн байна. (11:355) Даян баатрын хүн чулууны хувцас хэрэглэлийн өвөрмөц байдал нь монголын бусад нутгаас олддог түргийн үеийн хүн чулуудаас онц ялгарахын зэрэгцээ загалмай хэлбэрт сахиус зүүсэн байдлаар дүрсэлсэн нь уг дурсгалыг нүүдэлчдийн дунд христын шашин суртал дэлгэрч байсантай холбоотой эсэх талаарх судлаачдын маргааны гол эх үүсвэр болдог байна.

Нэгэн цагт дээрээ модон барилгатай байсан гэх энэ хүн чулууг нутгийнхан сүсэглэн хүндэтгэж, түүний хажуугаар мориноосоо заавал бууж өнгөрдөг заншил саяхан болтол байсан гэдэг. (11:136-137) Уг хөшөөг өнгөрсөн зууны сүүлээр Монгол нутгаар аялсан Оросын судлаач Г.Н.Потанин анх үзэж, судлаачдын анхааралд толилуулжээ. Тэр цагаас 1960-аад оныг хүртэл тусгайлсан судалгаа хийгдсэнгүй явж ирсэн бөгөөд харин Монголын археологч доктор Н. Сэр-Оджав 1960-аад оноос энэ дурсгалын талаар судалгаа хийж, Даян баатарын хүн чулууны хүзүүндэх зүүлтийг христос шашинтны загалмай хэмээн үзсэнээ хэд хэдэн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг.(1;133) Сүүлийн жилүүдэд доктор Д. Эрдэнэбаатар судалгаа хийж Даян баатарын зүүсэн зүүлт сахиусыг загалмай бус харин зарим түрэг овог аймгуудын дунд байсан онгон сахиус буюу тэдний тотем амьтан шувуу гэж үзжээ. (14;356-357) Мөн судлаач Ц.Төрбат Умай шүтлэгтэй холбон тайлбарласан нь буй. (7;356-357)

Харин бид энэхүү судалгаандаа Манжуур, Өвөр монголын нутгаас Японы эрдэмтдийн олсон загалмайнууд, түүнчлэн дэлхийн нэрт монголч эрдэмтэн Мостарт авгайн Ордос болон бусад нутгаас олж цуглуулсан эртний нэсторуудын олон тооны загалмай тэмдгүүдийн судалгаатай харьцуулсаны үндсэн дээр Даян баатарын хүзүүндэх сахиусыг шувуу хэлбэрт загалмай хэмээн үзэж байна. (зураг 3)

Харьцуулж буй дээрх олдворуудын дотор шувууг загалмай болгон дүрсэлсэн нь нилээд байгаа бөгөөд шувуунаас өөр адгуус амьтадыг загалмай хэлбэртэйгээр үйлдээгүй нь бидний анхаарлын ихээр татаж байгаа болно. Шувууг ийнхүү загалмай хэлбэртэйгээр үйлдсэн тухайд францийн монгольч эрдэмтэн Пелльо авгай үхэгсэдийн сүнстэй холбоотой байж болно хэмээн үзсэнтэй бид санал нэг байгаа бөгөөд магадгүй орчлонг орхин одсон өвөг дээдсийн сүнс онгодын орших орсон нь тэнгэр хурмаст, түүгээр дүүлэн, элин халигч нь шувуу гэж үзэх эртний ойлголтоос улбаатай байж болох юм. Тэгээд ч эртний нүүдэлчдийн тотемийн дунд сүлдэр болсон шувууд цөөнгүй буй. Энэ нь Христын

шашны нэстори урсгалыг шүтэх болсон нүүдэлчдийн хувьд загалмайг уламжлалт шүтээн сүлдэртэйгээ ижилсүүлж, бэлэгдэл болгосны илрэл байж болох юм.

Дээрх хэлбэрийн загалмайнууд эрт цагийн нэсторуудын булшнаас олддог бөгөөд мөн түүвэр олдворууд ч нилээд байдаг ажээ. Тэдгээрийг Ордос монголчууд тэр дундаа эмэгтэйчүүд дээл хувцсандаа зүүдэг байсан тухай Мостарт авгай дурдсан байдаг. (31;423-425)

Ийнхүү бид Даян баатарын хүн чулууны хүзүүн дэх сахиусыг шувуун хэлбэрт загалмай хэмээн үзвэл уг дурсгалын зориулагдсан эзэн нь нэстор шашныг түгээгч миссионер уу, эсхүл нэстор шүтлэгтэй баатар эр үү гэсэн асуултууд зүй ёсоор гарах бөгөөд эдгээрийн эхний хувьд бид боломжгүй хэмээн үзэж байна. Учир нь Дундад Ази, Долбоон мөрний сав, Өвөр монгол, Хойд хятадын нутгаас эртний христос шашны сургаал номлолыг түгээгч нарын /VII-XV зуун/ олон арван булш оршуулга нэгэнт олдож судлагдсан нь нүүдэлчдийнхээс ялгагдах зарим нэгэн онцлогтой ажээ.

Үүнд: Нэсторууд үхэгсэдээ оршуулахдаа хүн чулуу босгодоггүй харин хөшөө пойлуур босгон түүндээ христос шашны загалмай сийлэн (зураг4) /өвөр монгол, хятадаас олддог дурсгалууд лянхуа цэцгэн хээтэй байдаг/ эртний сири үсгийг дангаар нь буюу армян, уйгар, хятад үсгийн нэгтэй хамсуулан сири, армян, түрэг, хятад хэлээр оршуулгын бичээс бичиж үлдээдэг. Ингэхдээ Македоны Александр хаан ширээнд сууж дорно зүг их аян дайн хийсэн МТӨ 320 оноос он тооллын эхийг авсан байдаг. (26;75-86), (4;3-9), (27;347)

Харин үхэгсдээ оршуулах нүүдэлчдийн эртний зан үйлд хүн чулуу босгон онголох явдал /үүнд хүрэл зэвсгийн үед хамаарах буган чулуу ч холбогдоно/ түрэг монгол овог аймгууд гол байр эзэлдэг. Ингэхдээ их төлөв сурвалжит язгууртан ихэс дээдэстээ зориулан босгодог байсан нь энэ үед хамаарах булш оршуулгын судалгаанаас илэрхий. Гэхдээ ийнхүү хөшөө босгон онголох нь тэр цагийн оршуулах зан үйлийн салшгүй нэг хэсэг байсан хэдий ч уг хөшөөн дор үхэгсэдээ оршуулдгүй.

Иймээс Даян баатарын хүн чулууг нэстор шашины номлогч бус нэстор шүтлэгтэй баатар эр хэмээн бид үзэж байна. Магадгүй загалмайн шашинтан биш боловч Монголын Их хаад, Иль хаад, Цагаадайн хаант улсын эзэд хийгээд бусад олон жанжнуудын адилаар тухайн цагийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан уг шашныг эвээн хамгаалагч нэгэн байж болох юм.

### 3. Дааган чулууны дурсгал


"Дааган чулуу" нэртэй сондгой ганц цул боржин хад Баянхонгор аймгийн Баянбулаг сумын төвөөс зүүн хойш 10 км-т Даагын өндөр улаан хэмээх уулын өвөр бэлээс ундарсан Даагын булгийн зүүн этгээдэд буй.

Нутгийн хөгшдийн хуучилснаар "Дааган чулуу" хэмээх нэр нь дээр цагт уяачид наадамд уралдуулах даага шүдлэнгээ бага гэрийн дайтай энэхүү хадыг тойруулан уяж сойдог байсантай холбоотой гэдэг. Мөн энэ нь манай оронд цөөнгүй байдаг Адуун чулуу, Тэмээн чулуу гэсэн газар усны нэрийн адилаар монголчуудын сэтгэлгээн дэх ахуйтайгаа уялдсан алив зүйлсийн өвөр хэмжээг малтайгаа харьцуулж илэрхийлэх онцлогыг тод харуулж буй нэгэн жишээ болно.


Дааган чулууны баруун урд талын нүүрэнд эмээлийн даруулгын хиртэй олон тооны дугуй хонхорууд тэгш хэмтэйгээр байрлаж, тэдгээрийн гол хэсэгт уран нарийн дүрслэлтэй загалмай цоолборлосон нь урьд өмнө монгол орноос олдож байгаагүй өвөрмөц сонирхолтой дурсгал болно. Эл өгүүллийг бичигч бээр балчир ахуй насандаа гайхшран сонирхдог асан энэхүү дурсгалыг хожим 1996 оны зун оюутны амралтаар очихдоо нарийвчлан хэмжилт хийж, гэрэл зургийг нь буулган авсан юм. Уг боржин хадны өгөршилт, талстуудын ховхролтоос үзвэл тойруулан урласан дугуй хонхорууд нь дээр цагт одоогийнхоос илүү олон тоотой байсан нь илэрхий бөгөөд эдүгээ ийм хонхорын тоо нийт зуу гаруй буйгаас 80 орчим нь загалмай бүхий баруун урд хавтгай дээр байрлажээ. (зураг 5)

Эдгээрээс (Мэдэгдэж буй нийт дугуй хонхорын голч нь 1.6-7см) 3 нь 6.5-7см голчтой, дийлэнх голч 3.5-4 см ба 3.5-0.8 см гүнтэй ажээ.


Загалмай нь нарийн тэгш хэмтэй, үзүүр хэсгүүдэд нь 5-6 см голчтой булцуу хэлбэрийн дугуй хонхорууд буй болно.



Зураг 3. Мостарт ивгийн Ордосоос цуглуулсан  
загалмай тэмдэгүүд



Зураг 4. Өвөр Монголын Дархан Муумянгань тов  
Батхалгайд буй дурсгал



Зураг 5. Дааган чулууны дурсгал

Загалмай болон дугуй хонхоруудын дотор талыг сайтар өнгөлснөөс үзвэл уг дурсгалыг үлдээгчид чулууг засч, өнгөлөх арга технологийг гаргууд сайн эзэмшсэн болох нь илэрхий. Дурсгал дээрх загалмай христос шашны загалмайн сонгодог хэлбэрээр дүрслэгдсэн хийгээд дурсгал буй газар орон нь эртний нэстор шүтлэгт хүчирхэг Найман аймгийн /Их Монгол улс байгуулагдахын өмнөх XI-XIII зуун/ нутаг болох нь уг дурсгалыг загалмайтны шашинтай холбон тайлбарлах сэжүүрийг бидэнд өгч байгаа юм.

Нөгөөтэйгүүр Дааган чулуун дээр дүрсэлсэн зүйлс нь эртний нүүдэлчдийн од эрхсийг шүтэх шүтлэг, цаг улиралын солигдол, одон гаригийн орчил хөдөлгөөнтэй холбоо бүхий одтой тэнгэрийн зураг байхыг үгүйсгэх аргагүй ч баттай үндэслэл гарган дэлгэрэнгүй тайлбар гаргаж эс чадахын учир сонирхолтой байж болох энэхүү таамаглалыг энэ удаа орхил!

Ташрамд энэхүү бяцхан өгүүллийг бичихэд судалгааны ном зохиолоор харамгүй туслалцаа үзүүлсэн Унгарын монголч эрдэмтэн Хар Дорж /Кара Дьерд/ гуай болон Америк анд Дэн Хрушка нарт талархалаа илэрхийлье!

**Ном зүй:**

### **Монгол хэл дээр**

БНМАУ-ын түүх", I боть, УБ., 1966

Баяр Д. "Баруун монголд шинээр илэрсэн эртний бичгийн дурсгалууд"

*/Шинжлэх ухаан амьдрал/ 1990, №6, Улаанбаатар, х.37-40*

Далай Ч. "Монголын түүх (1260-1388)", /гутгаар дэвтэр/, УБ., 1992

ᠪᠠᠶ᠋ᠠᠷ ᠳᠤ. "ᠪᠠᠷᠠᠭᠤᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯᠳᠤ ᠰᠢᠨᠡᠭᠡᠷ ᠢᠯᠡᠷᠰᠡᠨ ᠡᠷᠲᠦᠨ ᠢᠪᠴᠢᠭᠢᠨ ᠳᠤᠷᠰᠠᠭᠠᠯᠤᠳᠤ"

ᠳᠠᠯᠠᠢ ᠴᠢ. "ᠮᠣᠩᠭᠣᠯᠢᠨ ᠲᠦᠭᠦᠬᠡ (1260-1388)", /ᠭᠤᠲᠠᠭᠠᠷ ᠳᠡᠪᠲᠦᠷ/, ᠤᠪ., 1992

ᠢᠰᠱᠠᠮᠴᠢ ᠨ. "ᠮᠣᠩᠭᠣᠯᠳᠤ ᠨᠡᠭᠳᠡᠰᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠠᠭᠳᠠᠵᠢ ᠮᠡᠮᠤᠯᠢᠰᠢᠮᠤ ᠪᠦᠷᠡᠯᠳᠡᠨ ᠮᠣᠭᠲᠤᠰᠢᠨ ᠨᠢ" 1974 ᠤᠪ /122-124/

Ишжамц Н. "Монголд нэгдсэн улс байгуулагдаж феодализм бүрэлдэн

*тогтсон нь" 1974 УБ /122-124/*

Пэрлээ Х. "Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь"

*/Studia Historica/ Tomus 1. Fasc 1. Улаанбаатар, 1959*

Төрбат Ц. "Дундад зууны нүүдэлчдийн шүтлэгийн холбогдолтой нэгэн дурсгал",

*/Угсатны судлал/, Том.115, Fasc.14, Улаанбаатар, 1997*

Сайшаал Р. "cielli\_ Hegea Q Dobciyea" Дээд дэвтэр, Хөх хот, 1987

Сэр-Оджав Н. "Баян-Өлгий аймгийн археологийн дурсгалыг судалсан нь"

*/Түүхийн судлал/ том. 8 Улаанбаатар, 1962*

Сэр-Оджав Н. "Эртний түрэгүүд / YI-YIII зуун/" Улаанбаатар, 1970

Сэр-Оджав Н. "Монголын эртний түүх" Улаанбаатар, 1977

Сүхбаатар Г. Жамсран Л. "БНМАУ түүхийн дээж бичиг" 1968 УБ

Хүүхэнбаатар Д. "Монгол гүрний элчин харилцаа (XIII зуун)" УБ 1961

Эрдэнэбаатар Д. "Түрэг угсааны аймгууд "Христос" шүтлэгтэй байсан уу

*(YI-YIII) зуун" /Corea-Mongol Joint Studies. 4 / p.355-359, 1995, Seoul, Korea*

Обрушански Борбала "Монгол Европын гүрнүүдийн элчийн харилцаа Несториан шүтлэгчийн үүрэг"

*/SUMMARIES OF CONGRESS PAPERS/, ОУМЭ-ийн YIII*

*их*

*хурал, Улаанбаатар, 2002*

### **Орчуулгын ном зохиол**

Гильом Де Рубрук "Дорно этгээдэд зорчсон минь" /Г. Нямдоржийн орчуулга/

*Улаанбаатар, 1988*

Жеованни Дель Плано Карпини "Монголчуудын түүх"

*/Ц. Шагдарсүрэнгийн орчуулга/ Улаанбаатар, 1988*

Марко Поло "Орчлонгийн элдэв сонин" /А. Очир, Б. Дорж,

*С. Идшинноров нарын орчуулга/ 1987 УБ*

- Рашид-Ад-Дин "Судрын чуулган" /Г. Сүрэнхорлоогийн орчуулга/  
Улаанбаатар, 1994  
"Монгол-Татаарууд Ази Европт" /хамтын бүтээл/ Улаанбаатар, 1984  
Саундерс Ж. "Монголын байлдан дагууллын түүх"  
/Ж. Гэндэндармын орчуулга/ УБ 1992  
Гумилев Л. Куркчи А. "Хар домог" /Г. Акимын орчуулга/ УБ 1992

### Гадаад хэл дээр

- Бартольд В. В. "О христианствѣ въ до-монгольскій періодъ"  
(По поводу семирѣченскихъ надписей) СПб., 1893. С.1-32.  
Бартольд В. В. "К вопросу о Чингизидах-Христианах" Избр. 1964.  
Гильом де Рубрук "Путешествие в восточные страны" Москва, 1957  
Гумилев Л. "В поисках вымышленного царства" 1994 Санкт-Петербург  
Гумилев Л. "Тысячелетие вокрук Каспия" 1993 Москва  
Галстяна А. "Армянские источники о монголах /извлечения  
из рукописей XIII-XIV вв/" 1962 Москва  
Джиованни дель Плано Карпини "История монгалов" Москва, 1957  
Истрин В. А. "Возникновение и развитие письма" Москва, 1965  
Малов С. Е. "Памятники древнетюркской письменности монголии  
и киргизии" Москва-Ленинград, 1959  
Маррь Н. "Надгробный камень изъ Семирѣчя, съ армянско-сирійской  
надписью 1323 г." /СПБ. Мартъ 1894/ стр.344-349  
Khazanov M. "The Spread of World Religions in Medieval Nomadic Societies  
of the Eurasian Steppes" In *The Nomadic Diplomacy,  
Destruction and Religion from the Pacific to the Adriatic* p.11-33  
Toronto Studies in Central and Inner Asia No.1 1994  
Moule A. C. "Christians in china before the year 1550" New York, 1977  
Pelliot P. "Chretiens d'Asie centrale et d'Extreme-Orient" T'oung Pao. 1914. V. 15  
Saeki P. Y. "The Nestorian documents and relics in China" Tokyo, 1951  
RENE GROUSSET "L'EMPIRE DES STEPPES  
/Attila, Gengis-khan, Tamerlan/" Paris, 1990, p.244-245  
Нус В. "Christianity in China, Martary, and Thibet" London, 1857

Бид өгүүлэлтэй холбогдуулж доорх гурван үгийг тайлбарлахыг зорив.

• **Хэрэйд** - Энэ хамлигийн нэрийн үүслийн тухайд тэдний дээд өвөг долоон хүүтэй. Тэд цөм бараан хээр царайтай байснаас тийнхүү хэрэйд хэмээн нэрлэсэн гэж Судрын чуулганд өгүүлсэн бол өдгөө зарим судлаачид хэрээ тотемтой байснаас үүссэн гэсэн саналтай байдаг. Харин бидний хувьд дээр өгүүлсэн Бар Хэврэүсийн зохиосон он дарааллын бичээс дэх хэрэйдүүд христийн шашинд орсон тухай баттай мэдээнд тулгуурлан христийн шашинтан хэрээстүүд буюу хэрэйд гэсэн монголын эртний овог аймгийн нэрсийн дотор элбэг тохиолдох олон тооны "д" дагавар авч бүтсэн нэр мэт санагдана. Ингэж нэрлэхийн бас нэг шалтгаан нь уг үгийн утга болно. Христийн шашны гол бэлэг тэмдэг болох загалмайг **cross** гэж англичууд /өрнө дахины бусад олон овог хэлнээ эл нэр ижил учир энд өгүүлсэнгүй болно/ нэрэлдэгийн адил бид **хэрээс** хэмээдэг нь авиа сэлгэснээс өөр өөрчлөлтгүй утга ижил үг болох нь үзтэл илэрхий ажээ. Бид "хэрэн тэнэх", хэрээс тавих, төмөр утсаар хэрэх зэрэг үг хэллэгээс харсан ч нэгэн зүйлийг нөгөөтэй нь хөндөлсүүлэн огтлолцуулсан дүрс илт ажиглагдана. Хэрэйд хэмээх нэрийн үүслийн тухайд бидний дэвшүүлэх санал энэ болно.



- **Загалмай** - Хэрээс тэмдгийг бид бас загалмай гэдэг. Энэ үгийн утга дүнгээс модыг **зааж** байшин барих, цонхны яс модыг заах (JеgeеeO) зэрэг хэллэгээс тод илэрнэ. Мөн загалмай зуухын тухай Доктор С.Дулам 2 жилийн тэртээ надад “Монгол ардын туульд загалмай зуух гэж гардаг. Энэ нь загалмай хэлбэрээр газар ухаж үйлдсэн зуух бөгөөд ухсан нүхний амсар дөрвөн зүгт харсан учир салхиний чиг аль ч зүгт эргэсэн асах галыг бадрааж байхаар зориулагдсан, басхүү тогоо тавихад тэгшхэмтэй зуух юм.” хэмээн өгүүлсэн билээ. Тэрчлэн энд буриад бөөгийн чанар авах зан үйл дэх модны тухай ч өгүүлж болно.
- **Эрхүд** – Монголчууд христийн шашинтныг ийнхүү нэрлэдэг асан хийгээд ийм нэрт овог өдгөө ч байсаар билээ. Христийн шашинтныг яагаад эрхүд гэдэг, энэ үгийн гарал, утга юу болохыг тодруулвал: Юань улсын үед холбогдох дөрвөлжин хийгээд хятад үсгээр “Мөнх тэнгэрийн хүчин дор ... Чингис, Өгөөдэй, Сэцэн, Өлзийт, Хүлэг хаад ... ” хэмээн эхэлдэг Хятадын Шэнь-сигээс олдсон гэрэлт хөшөөний бичээсэнд [elikow], хэмээн бичсэн нь персээр [erehun] буюу хутагт, номлогч, дээд хамба гэсэн утгатай ажээ. XIII зууны монголчууд нэстөр шашины төлөөлөгчдийг чингэж нэрлэж асан нь аажимдаа тэрхүү сургааль дагагсдыг нэрлэх нэр болон хувирч, улмаар эрхүн гэдэг нь олон тооны “д” дагавар авч Эрхүд болсон ажгуу. (31; 422)

### Summary

Yu. Boldbaatar

### Three monuments of nestorians

*A inscription of Ulaan tolgoi is Syriac inscriptions, which used by nestorians in Central Asia. The first Syriac inscription of Ulaan tolgoi is one of most important historical object of spread of ancient nestorian religion and inscription, because researchers could not read the inscription.*

*We have a hypothesis that stone statue of Dayan hero and monument of Daagan stone were built by nestorians.*

*We believe, the Over mentioned three are very important objects of influence of nestorians in history and culture of ancient and middle age Mongolia and Central Asia.*